



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/463

Номгон

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын  
цэцэрлэгийн их засварын нэмэлт  
ажлын гэрээ байгуулах

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1"а" дахь заалт, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1.Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын цэцэрлэгийн их засварын ажлыг дуусгаж, барилгыг ашиглалтад оруулж, ашиглахтай холбогдуулан төсөвт тусгагдаагүй, зайлшгүй хийх шаардлагатай 21,368,018 төгрөгийн нэмэлт ажил дээр "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалтыг үндэслэн гүйцэтгэгч компани болох "Даяар трейд" ХХК-тай гэрээ байгуулсугай.

2.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т зөвшөөрсүгэй.

3.Нэмэлт ажлыг хурдан шуурхай зохион байгуулж, хийж гүйцэтгүүлэн хүлээн авахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-д даалгасугай.

4.Төсвийн тухай хуулийн 46.3.1 дэх заалтын дагуу нэмэлт ажлын төсвийг санхүүжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т хариуцуулсугай.

ДАРГА



Д. МӨНХСАЙХАН

601210071